



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН  
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Хялбаршуулсан журмаар эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдааны дэг, журам болон шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалыг батлах тухай

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсэг, 25 дугаар зүйлийн 25.8.10 дахь заалт, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.“Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх шүүх хуралдааны дэг, журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлал”-ыг 2 дугаар хавсралтаар, “Шүүгдэгчид шүүх хуралдааны дэг болон эрх, үүрэг танилцуулсан баримт”-ыг 3 дугаар хавсралтаар, “Хохирогчид шүүх хуралдааны дэг болон эрх, үүрэг танилцуулсан баримт”-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.Шүүх хуралдааны дэг болон шүүхийн шийдвэр боловсруулах журам, аргачлалыг 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн бүх шатны шүүхүүд дагаж мөрдсүгэй.


3.Журам, аргачлалыг бүх шатны шүүхүүдэд хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Улсын дээд шүүхийн Тамгын газар (С.Заяадэлгэр)-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН  
ТАНХИМЫН ШҮҮГЧ

Б.БАТЦЭРЭН



## **ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДЭГ, ЖУРАМ**

### **1 дүгээр зүйл. Нийтлэг үндэслэл**

1.1. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх шүүх хуралдааныг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Гучин дөрөвдүгээр бүлэгт заасан шүүх хуралдааны ерөнхий нөхцөлийг удирдлага болгон мөн хуулийн Арван долдугаар бүлэгт заасан тусгай журам болон энэ журмын дагуу явуулна.

1.2. Энэхүү журам нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар хялбаршуулж явуулах шүүх хуралдаанд хамаарахгүй.

1.3. Шүүх эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийхгүй бөгөөд шүүх хуралдааныг нэг үе шаттайгаар явуулна.

1.4. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35.8 дугаар зүйлд заасан журмаар шүүхийн хэлэлцүүлэг явуулахгүйгээр, талуудын санал, зөвшөөрлийг үндэслэн прокурорын яллах дүгнэлтэд тусгагдсан нотлох баримтуудыг шинжлэн судалсанд тооцож болно.

1.5. Прокурор, шүүгдэгчээс бусад оролцогчийг шүүх хуралдаанд цахимаар оролцуулж болно.

1.6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд шүүгдэгч шүүх хуралдаанд өөрийгөө өмгөөлж оролцох хүсэлтийг бичгээр гаргасан бол өмгөөлөгч оролцуулахгүйгээр хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж болно.

1.7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шүүгдэгчийн өмгөөлөгч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд биечлэн оролцох боломжгүй болсон бол түүнийг цахимаар оролцуулах, эсхүл шүүгдэгчийн хүсэлт, зөвшөөрлийг үндэслэн шүүх хуралдааныг хойшлуулах, эсхүл өөр өмгөөлөгч оролцуулах талаар шүүх зохих арга хэмжээ авна.

### **2 дугаар зүйл. Шүүх хуралдааны дараалал**

2.1. Шүүгч шүүх хуралдааныг нээх, ирц шалгах, дэг тайлбарлах, шүүгч, прокурор, оролцогч, бусад оролцогчийг зарлах, татгалзан гаргах эрхийг хангах, оролцогчдын эрхийн хэрэгжилтийг шалгах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан нөхцөл байдлыг хянаж шалгах, нотлох баримт шинжлэн судлах эсэх талаар талуудын саналыг сонсох, талууд дүгнэлтээ танилцуулах, шүүгдэгч эцсийн үг хэлэх, шүүх хуралдааныг завсарлуулж шүүх шийдвэрээ гаргах, шүүхийн шийдвэрийг танилцуулах, шүүх хуралдааныг хаах гэсэн дарааллаар шүүх хуралдааныг явуулна.

2.2.Шүүх хуралдааныг нээх, ирц шалгаж санал асуух, дэг тайлбарлах, шүүгч, прокурор, оролцогч, бусад оролцогчийг зарлах, татгалзан гаргах эрхийг хангах, шүүх хуралдааны дэг сахиулах ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.20, 34.21, 35.1, 35.5 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулна.

2.3.Оролцогчийн шүүх хуралдаанд эдлэх эрх, үүрэг, шүүх хуралдааны дэгийг тусгасан маягтыг хуралдаан эхлэхээс өмнө шүүгчийн туслах, эсхүл шүүх хуралдааны нарийн бичгийн дарга урьдчилан танилцуулна. Шүүгч тухайн оролцогчоос эрх, үүрэгтэйгээ танилцсан эсэх, ойлгосон эсэхийг тодруулж, шаардлагатай бол тайлбарлан өгнө.

### **3 дугаар зүйл. Шүүх хуралдаанаар хянавал зохих нөхцөл байдал**

3.1.Шүүгч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас гадна дараах асуудлыг шүүгдэгчээс тодруулж, шүүх хуралдааны тэмдэглэлд тусгуулна:

3.1.1.Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол, прокурорын яллах дүгнэлт, түүнд дурдагдсан нотлох баримттай бүрэн танилцсан эсэх;

3.1.2.Мөрдөгч, прокурор, бусад этгээдийн зүгээс хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, нэр төрийг гутаан доромжлох, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж гэм буруугаа хүлээн зөвшөөрөхийг албадсан эсэх;

3.1.3.Өмгөөлүүлэх эрхтэй холбоотой хүсэлт, гомдол гаргах эсэх;

3.1.4.Шүүхэд шинээр хүсэлт, гомдол, баримт гаргах эсэх;

3.1.5.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд оролцогч энэ шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, прокурор эсэргүүцэл бичих эрхгүй болохыг ойлгосон эсэх;

3.2.Шүүгч шүүх хуралдаанд оролцож байгаа хохирогч, хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч, эсхүл тэдгээрийн өмгөөлөгчөөс дараах зүйлийг тодруулна:

3.2.1.Мөрдөн байцаалтад өгсөн мэдүүлэгт шинээр нэмэх, өөрчилж хэлэх зүйл байгаа эсэх;

3.2.2.Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг бодитой нөхөн төлөгдсөн, эсхүл хохирол, хор уршигийг нөхөн төлөх талаар шүүгдэгчийн гаргасан саналыг хүлээн авч буй эсэх.

3.3.Шүүгч нь улсын яллагч болон оролцогчийн шүүхэд шинээр гаргаж өгсөн баримт, хүсэлт, гомдолтой холбогдуулан нотлох баримтыг шинжлэн судлах, шүүхийн хэлэлцүүлэг явуулах эсэхийг шийдвэрлэнэ.

3.4.Шүүгдэгч хүсэлтээсээ татгалзсан, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан нөхцөл байдлын аль нэг нь хангагдаагүй, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл хэргийн зүйлчлэлийг өөрчлөх, эсхүл шүүгдэгчийг цагаатгаж болох үндэслэл тогтоогдвол шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33 дугаар бүлэгт заасан журмын дагуу хэргийг прокурорт буцаах, эсхүл яллагдагчийг шүүхэд шилжүүлж, хэргийг ердийн журмаар хянан хэлэлцэх асуудлыг шийдвэрлэнэ.

3.5.Энэ зүйлийн 3.4-т заасан нөхцөл байдал тогтоогдвол шүүх дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

3.5.1.Хэргийг прокурорт буцаах;

3.5.2.Хэргийг ердийн журмаар хянан шийдвэрлэх;

3.6.Шүүх хэргийг прокурорт буцаахгүйгээр, ердийн журмаар хянан хэлэлцэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 35.8 дугаар зүйлд заасан журмын дагуу шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хянан хэлэлцэх шүүх хуралдааныг даруй үргэлжлүүлэн явуулах, эсхүл талуудын саналыг харгалзан шүүх хуралдааныг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацааны /14 хоног/ дотор хийхээр товлон зарлаж болно.

3.7.Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэх талаар маргаагүй бөгөөд прокурорын яллах дүгнэлтэд тусгагдсан нотлох баримтыг талууд хүлээн зөвшөөрч, тэдгээрийг шинжлэн судалсанд тооцуулах санал гаргасан бол шүүгч шүүхийн хэлэлцүүлэг явуулах ажиллагааг дуусгавар болгож, улсын яллагч болон өмгөөлөгчийн дүгнэлт танилцуулах ажиллагааг үргэлжлүүлж явуулна.

#### **4 дүгээр зүйл. Улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт танилцуулах**

4.1.Улсын яллагч болон өмгөөлөгчөөс шүүгдэгчийн гэм буруу болон хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаарх дүгнэлтээ шүүхээс тогтоосон хугацаа, дарааллын дагуу шүүхэд танилцуулна.

4.2.Улсын яллагч, өмгөөлөгчийн дүгнэлтүүд агуулгын зөрөөгүй бол дүгнэлт танилцуулах ажиллагааг дуусгаж, шүүгч шийдвэр гаргахаар шүүх хуралдааныг завсарлуулна.

4.3.Шүүгч нь улсын яллагч, өмгөөлөгч дүгнэлт танилцуулсны дараа шүүгдэгч хүсэлт гаргавал түүнд эцсийн үг хэлэх боломж олгоно.


#### **5 дугаар зүйл. Шүүх шийдвэр гаргах, танилцуулах**

5.1.Шүүх энэ зүйлийн 3.1, 3.2-т заасан нөхцөл байдлыг хянасны үндсэн дээр гэм буруугаа сайн дураараа хүлээн зөвшөөрсөн шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсхүл эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх талаар прокурорын гаргасан саналыг баталж, шийдвэрээ танилцуулна.

5.2.Шүүгч шүүхийн шийдвэрийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.10 дугаар зүйлд заасан журмын дагуу уншиж сонсон, үндэслэлийг тайлбарлана.

5.3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд оролцогч давж заалдах гомдол гаргах, прокурор эсэргүүцэл бичих эрхгүй болохыг сануулна.

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн ... дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



## **ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР БОЛОВСРУУЛАХ ЖУРАМ, АРГАЧЛАЛ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Анхан шатны шүүхээс хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн шийдвэр нь шийтгэх тогтоол хэлбэртэй байх ба Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгээс бүрдэнэ.

1.2. Хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 29 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол боловсруулах журам, аргачлалд зааснаас товч буюу дараах байдлаар бичигдэнэ.

### **Хоёр. Шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэг**

2.1. Шүүхийн шийдвэрийн удиртгал хэсэг нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 29 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол боловсруулах журам, аргачлалын 1.1, 1.2, 1.3-т заасны дагуу бичигдэнэ.

2.2. Шүүгдэгчийн холбогдсон хэрэг Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад хамаарахыг бичихдээ хэргийн агуулгыг тусгахгүй.

### **Гурав. Шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэг**

3.1. Шүүхийн шийдвэрийн тодорхойлох хэсэгт хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдсан эсэх, оролцогчийн хуульд заасан эрхийг зөрчсөн, хязгаарласан эсэхийг дүгнэнэ.

3.2. Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болох нь нотлогдсон талаар дүгнэхдээ прокуророос шүүхэд шилжүүлсэн хэргийн агуулга, шүүхийн шийдвэрийн үндэслэл болсон нотлох баримтуудыг дурдана. Ийнхүү хэргийн нотлогдсон байдлыг дүгнэхдээ шүүгдэгчийн өгсөн мэдүүлэг болон бусад нотлох баримтын агуулга, шүүх тухайн нотлох баримтыг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, хууль ёсны гэж үзсэн талаарх дүгнэлтийг бичихгүй байж болно.

3.3. Шүүх хэргийн нөхцөл байдалд үндэслэн шүүгдэгчийн үйлдэл гэмт хэргийн шинжийг хэрхэн хангасан, хэргийн зүйлчлэл тохирсон эсэх талаар эрх зүйн дүгнэлт хийнэ.

3.4.Прокурорын санал болгож, шүүгдэгчийн хүлээн зөвшөөрсөн эрүүгийн хариуцлага нь хуульд нийцсэн эсэхийг дүгнэнэ.

3.5.Шүүгдэгч гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн нь баримтаар тогтоогдсон, эсхүл хохирол нөхөн төлөхөө бодитой илэрхийлсэн талаар дүгнэлт хийнэ.

3.6.Прокурорын саналын хүрээнд шүүгдэгчид Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан бол энэ талаар тогтоолд заана.

3.7.Шүүгдэгч тогтоол гарахын өмнө цагдан хоригдож байсан бол түүний цагдан хоригдсон хоногийг эдлэх ялд нь хэрхэн оруулан тооцохыг бичнэ.

3.8.Хэрэгт эд мөрийн баримт хураагдсан бол түүнийг прокурорын саналын хүрээнд хэрхэн шийдвэрлэхийг тогтоолд тусгана.

3.9.Шүүгдэгчээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал гаргуулах, эсхүл зардал төлөхөөс чөлөөлж шийдвэрлэсэн бол энэ талаар тогтоолд заана.

#### **Дөрөв. Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсэг**

4.1.Шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.8 дугаар зүйл, Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 29 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол боловсруулах аргачлалын Гурав дахь хэсэгт заасны дагуу бичнэ.

4.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд оролцогч шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, прокурор эсэргүүцэл бичих эрхгүй болохыг мөн хэсэгт дурдана.

#### **Тав. Шүүгчийн захирамж гаргах**

1.Шүүгдэгч хүсэлтээсээ татгалзсан, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан нөхцөл байдлын аль нэг нь хангагдаагүй, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл хэргийн зүйлчлэлийг өөрчлөх, эсхүл шүүгдэгчийг цагаатгаж болох үндэслэл тогтоогдвол шүүх хэргийг прокурорт буцаах, эсхүл ердийн журмаар хянан шийдвэрлэх талаар хууль зүйн дүгнэлт хийнэ.

2.Шүүх хуралдааныг хойшлуулах, хэргийг түдгэлзүүлэх, хэргийг прокурорт буцаах, хэргийг ердийн журмаар хянан хэлэлцэхээр шийдвэрлэхэд шүүгч захирамж гаргана.


3.Шүүх хэргийг прокурорт буцаахгүйгээр, ердийн журмаар хянан хэлэлцэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33 дугаар бүлэгт заасан журмын дагуу яллагдагчийг шүүхэд шилжүүлэх асуудлыг хамтад нь шийдвэрлэж, шүүгдэгч гэм буруутай эсэхийг хянан хэлэлцэх шүүх

хуралдааны даруй үргэлжлүүлэн явуулах, эсхүл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримтлан шүүх хуралдааны товыг шинээр тогтоох талаар захирамжид тусгана.

4.Шүүх хэргийг прокурорт буцааж шийдвэрлэсэн тохиолдолд яллагдагчид урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөх эсэх, хэрэгт хавсаргасан эд мөрийн баримт, битүүмжлэгдсэн, эсхүл хураагдсан хөрөнгө, орлого, бусад баримтад мэдээллийг хэрхэхийг хамтад нь шийдвэрлэнэ.

---oOo---

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны  
2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 13 дугаар  
тогтоолын 3 дугаар хавсралт



## ШҮҮГДЭГЧИД ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДЭГ БОЛОН ЭРХ, ҮҮРЭГ ТАНИЛЦУУЛСАН БАРИМТ

..... оны ... сарын ... өдөр

..... ШҮҮХ

Шүүх хуралдаан Монгол Улсын нэрийн өмнөөс явагдах бөгөөд шүүгч танхимд орж ирэх, мөн шүүхийн шийдвэр уншиж сонсоход шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн босож хүндэтгэл үзүүлнэ. Шүүхэд хандаж үг хэлэх, мэдүүлэг өгөхдөө суудлаасаа босно. Хэрэв хүндэтгэн үзэх шалтгаантай бол шүүгчийн зөвшөөрлөөр суудлаасаа мэдүүлэг өгч, үг хэлэх боломжтой. Түүнчлэн, шүүх хуралдааны дэг сахиулах талаар шүүгчийн гаргасан шийдвэрт захирагдана. Шүүгдэгч та, дэг зөрчвөл эхний удаа сануулж, дахин зөрчил гаргавал таныг шүүх хуралдааны танхимаас гаргаж, зөвхөн шүүхийн шийдвэр танилцуулахад байлцуулна.

### ШҮҮГДЭГЧИЙН ЭРХ:

- Шүүх хуралдаанд биечлэн оролцох, ямар хэрэгт шүүгдэж байгаагаа мэдэх;
- Яллах дүгнэлтийн үндэслэл болсон нотлох баримттай танилцах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах хүсэлт гаргах, шүүхэд шинээр баримт сэлт гаргаж өгөх;
- Эх хэлээрээ, эсвэл өөрийн сайн мэдэх хэлээр мэдүүлэг өгөх, шаардлагатай бол орчуулагч, хэлмэрч авах, мэдүүлэг өгөхөөс татгалзах;
- Өөрийн гэм буруугүйг, эсвэл хэргийн байдлыг нотлох үүрэг хүлээхгүй бөгөөд өөрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх /дуугүй байх эрх/;
- Өмгөөлөгч сонгон авах, солих, өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах, амаар, эсхүл бичгээр чөлөөтэй харилцах;
- Шүүгч, прокурор, нарийн бичгийн даргыг татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;
- Шүүх хуралдаанд мэдүүлэг өгөх, шүүх хуралдааны төгсгөлд эцсийн үг хэлэх, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах тухай хүсэлт гаргах;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр давж заалдах журмаар гомдол гаргах;
- Шүүгч шийдвэр гаргахаас өмнө эрүүгийн хариуцлагын талаарх тохиролцооноос татгалзах;
- Бусад оролцогчоос гаргасан гомдол, эсэргүүцэлтэй танилцах, түүнд тайлбар гаргах.

### ШҮҮГДЭГЧИЙН ҮҮРЭГ:

- Шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудсан цагт хүрэлцэн ирэх;
- Шүүх хуралдааны дэг сахих, хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах;
- Шүүхийн шийдвэр, шүүгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулахгүй байх;
- Оролцогч болон хэргийн бусад оролцогчид хууль бусаар нөлөөлөхгүй байх.

### ШҮҮГДЭГЧИД ТАВИГДАХ АСУУЛТ:

- Хялбаршуулсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл, журам, хууль зүйн үр дагаврыг ойлгосон эсэх;
- Өмгөөлүүлэх эрхтэй холбоотой хүсэлт, гомдол гаргах эсэх;
- Шүүхэд шинээр хүсэлт, гомдол, баримт гаргах эсэх;
- Гэмт хэрэг үйлдсэн гэм буруугаа сайн дураар хүлээн зөвшөөрсөн эсэх; мөрдөгч, прокурор, бусад этгээдийн зүгээс хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, нэр төрийг гутаан



доромжлох, хуурч мэхлэх зэрэг хууль бус арга хэрэглэж гэм буруугаа хүлээн зөвшөөрөхийг албадсан эсэх;

- Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол, прокурорын яллах дүгнэлт, түүнд дурдагдсан нотлох баримттай бүрэн танилцсан эсэх;
- Буруутгагдаж буй хэргийн нөхцөл байдал, прокурорын сонсгосон ял, хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээ, түүний хууль зүйн үр дагаврыг ойлгож, хүлээн зөвшөөрөх эсэх;
- Гэмт хэрэг үйлдэж учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлсөн, эсхүл хохирол, хор уршгийг нөхөн төлөхөө бодитой илэрхийлсэн эсэх;
- Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хүлээн зөвшөөрөх эсэх;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд оролцогч шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах, прокурор эсэргүүцэл бичих эрхгүй болохыг ойлгосон эсэх.

**ТАНИЛЦСАН ШҮҮГДЭГЧ:** ..... / ...../

Гарын үсэг

овог, нэр



Он сар өдөр

2023/ШЦТ/

.....

## МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

..... шүүхийн шүүгч ..... даргалж, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ....., улсын яллагч ....., шүүгдэгч ....., өмгөөлөгч ....., хохирогч ..... нарыг оролцуулан тус шүүхийн ... танхимд нээлттэй явуулсан хуралдаанаар ..... прокурорын газрын хяналтын прокуророос хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэхээр яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн ..... дугаартай хэргийг ..... оны ... сарын ....-ийн өдөр хүлээн авсныг энэ өдөр хянан хэлэлцэв.

Шүүгдэгчийн биеийн байцаалт: */Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 29 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол боловсруулах журам, аргачлалын 1.3-т заасны дагуу бичнэ/*

Шүүгдэгчийн холбогдсон хэрэг Эрүүгийн хуулийн ямар зүйл, хэсэг, заалтад хамаарах: */Прокурорын яллах дүгнэлтэд тусгагдсан хэргийн зүйлчлэлийг бичнэ/*

## ТОДОРХОЙЛОХ нь:

Гэм буруугийн талаар:

Шүүгдэгч ..... нь ..... /хэргийн үйл баримт/ гэмт хэргийг үйлдсэн болох нь шүүгдэгчийн үйлдсэн хэргээ хүлээн мэдүүлсэн мэдүүлгээс гадна гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээж авсан тухай тэмдэглэл (хавтаст хэргийн .... дахь/дэх хуудас), хохирогч .....-ны мэдүүлэг (хавтаст хэргийн .... дахь/дэх хуудас), гэрч .....-ийн мэдүүлэг (хавтаст хэргийн .... дахь/дэх хуудас), Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2023 оны .... дугаар сарын ....-ны өдрийн .... дугаартай шинжээчийн дүгнэлт (хавтаст хэргийн .... дахь/дэх хуудас) зэрэг нотлох баримтаар нотлогдон тогтоогдсон гэж дүгнэв.

Шүүхийн хэлэлцүүлэгт талуудаас шинжлэн судалсан (эсхүл: Яллах дүгнэлтэд тусгасан бөгөөд талуудаас шинжлэн судалснаар тооцуулсан) дээрх нотлох баримтуудыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж бэхжүүлсэн байх бөгөөд эдгээр нь энэ хэрэгт хамааралтай, хэргийг эцэслэн шийдвэрлэхэд хүрэлцээтэй байна.

Нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдал нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн .... дугаар зүйлийн .... дэх/дахь хэсэг/заалтад заасан гэмт хэргийн шинжийг бүрэн агуулжээ.

Шүүгдэгч ..... нь өөрт холбогдох хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлүүлэх хүсэлтийг сайн дураар гаргаснаа илэрхийлж байх ба түүнд эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий харьцах, хуурч мэхлэх зэрэг хууль бусаар хэрэг хүлээлгэсэн нөхцөл байдал тогтоогдоогүй болно.

Энэ хэргийн улмаас хохирогч ..... -д учирсан ..... төгрөгийн хохирлыг шүүгдэгч ..... нь төлж барагдуулсан байх тул түүнийг бусдад төлөх төлбөргүй гэж үзэв. (эсхүл: шүүгдэгч ..... нь хохирогчид учирсан хохирлыг сайн дурын үндсэн дээр төлж барагдуулахаа бодитоор илэрхийлсэн байх тул түүнээс ..... төгрөгийг гаргуулан хохирогч .....-д олгохоор шийдвэрлэв.)

Эрүүгийн хариуцлагын талаар:

Прокурорын санал болгож, шүүгдэгчийн хүлээн зөвшөөрсөн ..... /Прокурорын яллагдагчтай тохиролцсон ял, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг бичнэ/ ял, албадлагын арга хэмжээ нь Эрүүгийн хуульд нийцсэн бөгөөд шүүгдэгч тухайн эрүүгийн хариуцлагын хууль зүйн үр дагаврыг ухамсарлан ойлгосон байх тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар прокурорын саналыг баталж, шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх хууль зүйн үндэслэлтэй байна.

Иймд шүүгдэгч .....-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн ..... дугаар зүйлийн ..... дэх/дахь хэсэг/заалтад зааснаар ..... ял шийтгэх (эсхүл: Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн ... дугаар зүйлийн ... дэх/дахь хэсэг/заалтад заасныг журамлан шүүгдэгч .....-д мөн хуулийн тусгай ангийн ... дугаар зүйлийн ... дэх/дахь хэсэг/заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр тэнсэж ..... албадлагын арга хэмжээ хэрэглэх) нь зүйтэй гэж шүүх дүгнэв.

*Хэрэв Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлд заасан хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан, шүүгдэгч тогтоол гарахаас өмнө баривчлагдсан, цагдан хоригдсон, түүнчлэн хэрэгт эд мөрийн баримтаар хуурагдсан зүйл болон битүүмжлэгдсэн эд хөрөнгө, мөн шүүгдэгчээс гаргуулах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал байгаа бол тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тогтоолд дүгнэлт хийнэ.*

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 36.2, 36.3, 36.6, 36.7, 36.8, 36.10 дугаар зүйлүүдэд заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. .... овогт .....-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн ... дугаар зүйлийн ... дэх/дахь хэсэг/заалтад заасан “.....” гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсугай.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн ... дугаар зүйлийн ... дэх/дахь хэсэг заалтад зааснаар шүүгдэгч .....-д ял шийтгэсүгэй. (Эсхүл Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн ... дугаар зүйлийн ... дэх/дахь хэсэг/заалтыг журамлан шүүгдэгч .....-д мөн хуулийн тусгай ангийн ... дугаар зүйлийн ... дэх/дахь хэсэг/заалтад заасан хорих ялыг оногдуулахгүйгээр тэнсэж, ..... албадлагын арга хэмжээ хэрэглэсүгэй.)

....

*Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлд заасан хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авсан, шүүгдэгч тогтоол гарахаас өмнө баривчлагдсан, цагдан хоригдсоныг ял эдэлсэн хугацаанд оруулж тооцсон,*

*түүнчлэн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан зүйл болон битүүмжлэгдсэн эд хөрөнгө, мөн шүүгдэгчээс гаргуулах хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардал байгаа бол тухайн асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар тусгана.*

6. Шийтгэх тогтоолыг гардаж авсан, эсхүл хүргүүлснээс хойш 14 хоногийн дотор зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэлээр оролцогч давж заалдах гомдол гаргах улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

7. Дээр дурдсан үндэслэлээр оролцогч давж заалдах гомдол гаргасан, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичсэн тохиолдолд шийтгэх тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол хуулийн хүчин төгөлдөр болтол шүүгдэгч .....-д авсан ..... таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ ..... НЭР